


ЗӨВШӨӨРӨВ:

ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ЭРДЭМБИЛЭГ

БАТЛАВ:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН СУДЛАЛЫН
МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА



САЛБАР
ЗӨВЛӨЛ
23

Д.ЦЭНД-АЮУШ

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ИХ ЭМЧИЙН
“МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН СУДЛАЛ”
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Мэргэшлийн индекс: S(r) 091702

Сургалтын хугацаа: 2 жил

УЛААНБААТАР ХОТ

2022 ОН

БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ:

Д.Цэнд-Аюуш	Уламжлалт анагаах ухаан судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн ерөнхий мэргэжилтэн, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургуулийн захирал, Анагаах ухааны доктор, профессор
Ш.Болд	Уламжлалт анагаах ухаан судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Монголын Анагаахын Шинжлэх Ухааны Академийн ерөнхийлөгч, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургуулийн профессор, Академич, Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор
Т.Алимаа	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль, Монгол анагаах ухаан судлалын тэнхимийн дэд профессор, Анагаах ухааны доктор, дэд профессор

ХАМТРАН АЖИЛЛАСАН:

Ч.Чимэдрагчаа	Уламжлалт Анагаах Ухаан, Технологийн Хүрээлэнгийн захирал, Академич, Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор
С.Доржбат	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль, Монгол анагаах ухаан судлалын тэнхимийн эрхлэгч, Анагаах ухааны доктор
С.Хишигжаргал	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль, Дотор өвчин судлалын тэнхимийн эрхлэгч, Анагаах ухааны доктор, профессор
Ч.Батнайрамдал	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль, Монгол Анагаах Ухааны Төв Эмнэлгийн захирал, Анагаах ухааны доктор, дэд профессор
Б.Цэрэнцоо	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль, Уламжлалт жор судлалын тэнхимийн эрхлэгч, Анагаах ухааны доктор, дэд профессор
Н.Оюунцэцэг	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль, Уламжлалт эмчилгээний тэнхимийн эрхлэгч, Анагаах ухааны доктор, дэд профессор

Д.Шинэтуяа	Уламжлалт Анагаах Ухаан, Технологийн Хүрээлэнгийн Эмнэлгийн дарга, Анагаах ухааны магистр, тэргүүлэх зэргийн эмч
Д.Амарзаяа	Уламжлалт Анагаах Ухаан, Технологийн Хүрээлэнгийн Эмнэлгийн чанарын албаны дарга, Анагаах ухааны доктор, зөвлөх зэргийн эмч
Б.Золзаяа	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль, Монгол анагаах ухаан судлалын тэнхимийн багш, Анагаах ухааны магистр

ХЯНАСАН:

П.Эрхэмбаяр	Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Нийгмийн эрүүл мэндийн магистр
Б.Туяа	Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн
Д.Дондогмаа	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны ахлах мэргэжилтэн, Анагаах ухааны магистр
М.Оюунчимэг	Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын Уламжлалт анагаах ухааны хэлтсийн Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ хариуцсан ахлах шинжээч

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн
26 дугаар тогтоолоор зөвшөөрөв.

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ИХ ЭМЧИЙН
“МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН СУДЛАЛ”
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эмнэлгийн байгууллагад ажиллаж буй уламжлалт анагаах ухааны их эмч нарын мэдлэг, чадвар, хандлагыг шинжлэх ухааны хөгжил, нийгмийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн төгсөлтийн дараах сургалтаар тасралтгүй дээшлүүлэх нь чухал юм. Монгол Улсын хэмжээнд 2021 оны байдлаар Уламжлалт анагаах ухааны их эмч 1142 ажиллаж, нийт эмч нарын 11.1%-ийг эзэлж байна.

Эдүгээ дэлхийн анагаах ухааны хөгжлийн чиг хандлага, Монгол хүний өвчлөл, нас баралт, тархалтын судалгаанаас үзэхэд уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, төрөлжсөн нарийн мэргэжлийн УАУ-ны мэргэшсэн эмч бэлтгэх хэрэгцээ, шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Иймд “Төгсөлтийн дараах үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн А/445 дугаар тушаалаар Уламжлалт анагаах ухааны чиглэлийн 8 үндсэн мэргэшлийн индекс батлагдсан нь төгсөлтийн дараах сургалтад томоохон дэвшил болж, сургалт явагдах эрхзүйн орчин бүрдсэнээр энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО

Уламжлалт анагаах ухааны чиглэлээр хүн амд эмнэлгийн анхан шатны чанартай тусламж үзүүлж, зонхилон тохиолдох өвчин эмгэгээс урьдчилан сэргийлж эрүүлжүүлэх, өвчин эмгэгийг оношлох, эмчлэх онолын мэдлэг, ур чадвар, дадал, хандлагыг эзэмшсэн уламжлалт анагаах ухааны мэргэжлийн эмчийн түвшинд эрүүл мэндийн бүх шатлалын эмнэлэгт бие даан ажиллах чадвартай Уламжлалт анагаах ухааны эмч (Doctor of traditional medicine) бэлтгэхэд оршино.

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

“Монголын уламжлалт анагаах ухаан судлал”-ын сургалтын хөтөлбөрөөр бэлтгэх эмчийн дүр зураг:

Хүн амыг уламжлалт анагаах ухаанаар өвчнөөс урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон; зонхилон тохиолдох өвчний оношилгоо, эм заслын эмчилгээ хийхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн; эмчлүүлэгчид энэрэх сэтгэлээр хандаж, эмчийн ёс зүйг чандлан баримталдаг, багаар ажиллан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үр дүнтэй үзүүлж чаддаг уламжлалт анагаахын эмч байна.

ДӨРӨВ. СУРГАЛТЫН ЗОРИЛТ

Алсын харааг биелүүлэхэд чиглэсэн дараах цөм чадамжтай байна:

1. Уламжлалт анагаахын ерөнхий мэргэшлийн эмч байх (*Traditional medical doctor*)
2. Мэргэжлийн байх (*Professional*)
3. Тасралтгүй суралцагч байх (*Continous Learner*)
4. Харилцагч байх (*Communicator*)
5. Хамтрагч байх (*Collaborator*)
6. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч байх (*Community Health Advocate*)
7. Зохион байгуулагч, манлайлагч байх (*Leader*)

Энэхүү цогц чадамж нь Уламжлалт анагаахын эмчийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдлэг, чадвар, хандлагын тухай ойлголт юм. Үүнд:

1. Монголын уламжлалт анагаах ухаан судлалын ерөнхий мэргэшлийн эмч(*Traditional medical doctor*):

- Хүн амын дунд зонхилон тохиолдох өвчний шинж тэмдгийг таних, ялган оношлох, уламжлалт анагаах ухааны анхан шатны арга хэмжээг авах;
- Өвчтөнөөс асуумж авах, үзэх, хүрэлцэх шинжилгээ хийх, өвчтөний сэтгэл зүй, нийгмийн нөхцөл байдлыг үнэлэх оношилгоо, эмчилгээ, хяналтын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх;
- Төрөлжсөн мэргэжлийн төв эмнэлэг, аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг, сум, тосгоны, өрхийн эрүүл мэндийн төвд уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээний гардан үйлдлийг бүрэн эзэмшиж, тусламж, үйлчилгээг аюулгүй үзүүлэх;
- Өвчтөний хувийн нууцыг хадгалах;
- Өвчтөний өвдөлт, сэтгэл зовнилд анхаарал хандуулах;
- Төрөлжсөн мэргэжлийн төв эмнэлэг, аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг, сум, тосгоны, өрхийн эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нөөц бололцоонд тулгуурлан, тусламж, үйлчилгээг сонгон шийдвэрлэх;
- Эрүүл мэндийн байгууллагын бүртгэл, тайлан, мэдээг зохих журмын дагуу цаг хугацаанд нь хөтлөх.
- Нэрвэгдэгсдэд эмнэлгийн анхны болон амилуулах суурь тусламж үзүүлэх мэдлэг, чадвар эзэмших

2. Мэргэжлийн байх (Professional):

- Төрөлжсөн мэргэжлийн төв эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, сум, тосгоны, өрхийн эрүүл мэндийн төвд өөрийн мэргэшлээр хувь нэмэр оруулах хүсэл эрмэлзэлтэй байх;
- Өвчтөнг хувь хүний хувьд хүндэтгэж, эмчилгээний зөв шийдвэр гарган ажиллах;
- Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөн, түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүмүүстэй хүндэтгэлтэй харилцах.

3. Суралцагч байх (Continous Learner):

- Боловсруулах, хураах, бүрхүүл хуулах, тэнсэх зэрэг өвөрмөц эмчилгээний аргын дагуу эм, идээ ундаа, явдал мөр, заслын эмчилгээг хийх мэдлэг, ур чадвар олгоно.
- Уламжлалт анагаах ухааны үндсэн онолын дагуу өвчин эмгэгээс цаг улирал, бие махбодын өвөрмөц чанар, насны байдалтай нь уялдуулан урьдчилан сэргийлэх эрүүлжүүлэх мэдлэг, ур чадварыг эзэмшүүлнэ.
- Уламжлалт анагаах ухаанаар зөвлөгөө үзүүлэх арга зүйг эзэмшүүлнэ.
- Харилцааны ур чадвар эзэмшүүлнэ.
- Оношилгооны ур чадвар эзэмшүүлнэ.
- Эмнэл зүйн ур чадвар эзэмшүүлнэ.
- Сургалт сурталчилгааны ур чадвар олгоно.
- Эрдэм шинжилгээ судалгааны арга зүйг эзэмшүүлнэ.

4. Харилцагч (Communicator):

- Үйлчлүүлэгч болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй зүй зохистой үг хэллэг ашиглан зөв боловсон харилцах;
- Үйлчлүүлэгчид шаардлагатай мэдээлэл өгөхдөө ойлгоход хялбар үг хэллэг ашиглан тайлбарлах;
- Шаардлагатай тохиолдолд эмчлүүлэгчийн оношилгоо, эмчилгээний талаар бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй зөвлөлдөх.

5. Хамтрагч (Collaborator):

- Тухайн орон нутгийн уламжлалт анагаахын тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар мэргэшлийн эмч нартай мэдээлэл солилцож, хамтран ажиллах.
- Эмнэлгийн бусад тасгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй мэргэжлийн мэдлэг, мэдээллээ хуваалцаж хамтран ажиллах.
- Эмнэлгийн бусад ажилтан, мэргэжилтэнтэй багаар ажиллах чадвартай байх

6. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч (Community Health Advocate):

- Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч байхын тулд урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх, сургалт сурталчилгаа явуулах;
- Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

7. Зохион байгуулагч, манлайлагч (Leader):

- Уламжлалт анагаахын тусламж, үйлчилгээг зохицуулах, манлайлан ажиллах үүргээ ухамсарлах;
- Эмнэлэг, эрүүл мэндийн төв дэх тусламж, үйлчилгээ үзүүлэх багийг манлайлан ажиллах үүргээ ухамсарлах.

ТАВ. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

5.1.Сургалтын чиглэл, хугацаа, байршил

- Төгсөлтийн дараах сургалт явуулах зөвшөөрөл авсан эрх бүхий байгууллагууд
- Сургалтын нийт хугацаа 2 жил байна. Тойролтын хугацааг үндсэн болон бусад сүлжээ сургалт эрхлэх эмнэлгүүдийн эмгэг судлалын тасгийн онцлог, хүчин чадалд тохируулан зохицуулна.
- Суралцагч эмчийн өдөр тутмын болон 7 хоногийн үйл ажиллагааны тодорхой хуваарийг Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль, Монгол Анагаах Ухааны Төв Эмнэлэг, Уламжлалт Анагаах Ухаан, Технологийн Хүрээлэн, Оточ Манранба Их Сургуулийн эмнэлэг болон бусад сүлжээ сургалт эрхлэх эмнэлгүүд боловсруулна.
- Сургалт эрхлэх байгууллага дээр зохион байгуулагдаж буй Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлага, Халдварын сэргийлэлт, хяналт, Амилуулах суурь тусламж, Эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль, журам, зөрчлийн тухай хууль, хувь хүний нууцтай холбоотой хууль, Эмнэлгийн эрх зүйн чиглэлээр сургалтад заавал хамрагдана.

5.2.Зайлшгүй танин мэдэж, суралцах шаардлагатай шинж тэмдэг, суурь мэдлэг, өвчин, гардан үйлдэл

Сургалтын агуулгын хүрээнд монголын уламжлалт анагаах ухаан судлал үндсэн мэргэшлээр суралцаж байгаа эмч нь сургалтын төгсгөлд орон нутагт ганцаараа бие даан тусламж, үйлчилгээ үзүүлж чадах түвшинд хүрэхийн тулд эмнэл зүйн сургагч багшийн хяналт дор амбулаториор ирэх өвчтөн, хэвтэн эмчлүүлэгсдийн УАУ оношилгоо, эмчилгээг хариуцан ажиллах явцдаа дараах шинж тэмдэг, өвчин, гардан үйлдлийг гүйцэтгэж, үндсэн мэргэшлийн сургалтад оролцоно.

5.2.1.Өвчний шинж тэмдэг (signs and symptoms) (аль ч тойролтод тохиолдох):

Өвчний түүх, бодит үзлэгт үндэслэн эрэмбэлэн ангилж, ялган оношилгоо хийн, анхан шатны эмчилгээ, уламжлалт анагаахын тусламж үйлчилгээг үзүүлж чаддаг болох:

1. Халууралт (*Fever*)
2. Шарлалт (*Jaundice*)
3. Толгой өвдөлт (*Headache*)
4. Ухаан алдалт, балралт (*Altered level of consciousness*)
5. Таталт (*Seizure*)
6. Ханиалгалт, цэр гаралт (*Coughing, Excretion sputum*)
7. Цээжээр өвдөлт (*Chest pain*)
8. Дотор муухайралт, бөөлжилт, хоосноор огиулах (*Nausea, Vomiting*)
9. Хэвлийн өвдөлт (*Stomachache*)
10. Суулгалт (*Diarrhea*)
11. Нуруугаар өвдөлт (*Back pain*)
12. Мөчдийн саажилт (*Paralysis*)
13. Хаван /цайвар, усан, суваг хаван/ (*Edema*)
14. Үений өвдөлт (*Arthralgia*)
15. Зүрх зогсолт (*Cardiac arrest*)
16. Жихүүцэх (*Shivering*)
17. Эвшээх, суниах (*Yawning, Stretching*)
18. Таван мэдрэхүй үл тодрох (*dullness of the sense organs*)
19. Сэтгэл санаа тогтворгүй болох (*Mental instability*)
20. Сүүж бэлхүүс, яс үесээр хатгуулж өвдөх (*Stabbing pain in the hips, waist, bones and joints*)
21. Энд тэндгүй тогтворгүй өвдөх (*Shifting pain*)
22. Идээ шингэсний дараа, өглөө үүрээр, үдшийн бүрийд өвчин хөдлөх (*Arising after digestion, in the evening and around dawn*)
23. Аманд гашуун амт амтагдах (*Bitter taste in the mouth*)
24. Идээ шингэх үед өвдөх (*Pain during digestion*)
25. Хоолонд дургүй болох (*Loss of appetite*)

5.2.2.Зайлшгүй суралцаж, таньж мэдэх шаардлагатай өвчин эмгэгүүд:

1. Үндсэн зургаан өвчин (Хийн өвчнүүд, Шарын өвчнүүд, Бадганы өвчнүүд, Бор өвчнүүд, Цусны өвчнүүд, Шар усны өвчнүүд) The six basic diseases (Wind disorders TMA, Bile disorders TMB, Phlegm disorders TMC, Brown phlegm disorder TMD, Blood diseases TME06, Yellow fluid disorders TMM15)
2. Дотор өвчин (Эс шингэсэн өвчнүүд) Internal disorders (Diseases caused by indigestion TME00)
3. Их архаг өвчнүүд (Бэтэг өвчнүүд, хаван өвчнүүд) Chronic diseases TME05 (Mass formation disorders TME01, Swelling disorders TME02-04)

4. Цул, сав эрхтний өвчнүүд (5 цул, 6 сав эрхтний өвчнүүд) Vital and vessel organ disorders (The five vital, six hollow organ disorders) TMK00-TMK09
5. Хэсэг бусаг өвчнүүд Miscellaneous disorders TMM00-TMM18
6. Хамт төрсөн яр өвчнүүд Congenital wound diseases TMQ00
7. Эмэгтэйчүүдийн өвчин Gynecological disorders TMR00
8. Ад донгийн өвчин Diseases caused by demons (evil spirits) TMS00-TMS04
9. Хорын өвчин Poisoning disorders TMU00-TMU07
10. Уламжлалт анагаах ухаанаар хүчжүүлэх, шимжүүлэх тухай Restore body strength and rejuvenate with traditional medicine TMW00-TMW02
11. Өвчнөөс урьдчилан сэргийлэх уламжлалт анагаах ухааны ёс Tradition of preventive traditional medicine

5.2.3. Гардан үйлдлийн жагсаалт :

1. Биеийн өвөрмөц чанарыг тодорхойлох
2. Эмэнд орж буй эмийн түүхий эдийн хэсгийг зөв таних
3. Зонхилох эмийн түүхий эдүүдийн нэршлийг (латин, төвд, монгол) нэрлэх
4. Хийн гаралтай гэгийг арилгах тан, талх эмийн технологитой танилцаж, найруулах
5. Шарын гаралтай гэгийг арилгах тан, талх эмийн технологитой танилцаж, найруулах
6. Бадганы гаралтай гэгийг арилгах тан, талх эмийн технологитой танилцаж, найруулах
7. Цусны гаралтай гэгийг арилгах тан, талх эмийн технологитой танилцаж, найруулах
8. Шар усны гэгийг арилгах тан, талх эмийн технологитой танилцаж, найруулах
9. Хорхойн өвчнийг анагаах тан, талх эмийн технологитой танилцаж, найруулах
10. Жил суудлыг олж тооцоолох, мэнгэ үсэргэх
11. Махбодын зурхайгаар тооцож олох
12. Асуух шинжилгээний аргаар дан, хавсарсан, хурсан өвчний зовуурь, шаналгаа, шинж тэмдгийг ялгах
13. Хэл оношилгоо хийх
14. Таван цэцэгт илрэх өөрчлөлтөөр онош тавих, шинж тэмдгүүдийг ялгах
15. Судас оношилгоо хийх
16. Бэлчир орон тэмтрэх
17. Зонхилон тохиолдох өвчний үед ханах засал хийх
18. Зонхилон тохиолдох өвчний үед төөнө засал хийх
19. Шивүүр засал хийх
20. Самнуур засал хийх
21. Түрэм засал хийх
22. Зүүлэх төөнө хийх
23. Тогтмол, дахимал, гулгуур бумба тавих
24. Зөгийн балаар татах эмчилгээ хийх
25. Хиймэл 5 рашааныг найруулах, бэлтгэх, өвчтөнг оруулах

26. Хүйтэн, халуун жин засал хийх
27. Туулгах засал хийх
28. Бөөлжүүлэх засал хийх
29. Шавар эмчилгээг тохирох хэлбэрээр тавих (бээлий, оймс, урт, богино өмд, мөрөвч, тохойвч, өвдгөвч)
30. Ороох засал хийх (сэндэн, халгай)
31. Бүх биеийн зөөлөн бариа хийх
32. Шимжүүлэх бариа хийх
33. Зүрх судасны зарим эмгэгүүдийн үед бариа хийх
34. Амьсгалын замын зарим эмгэгүүдийн үед бариа хийх
35. Хоол боловсруулах замын зарим эмгэгүүдийн үед бариа хийх
36. Бөөр, шээсний замын зарим эмгэгүүдийн үед бариа хийх
37. Эмэгтэйчүүдийн зарим эмгэгүүдийн үед бариа хийх
38. Яс булчингийн тогтолцооны зарим эмгэгүүдийн үед бариа хийх
39. Тархины доргилтын бариа хийх
40. Ясны бариа хийх
41. Зонхилон тохиолдох эмгэгүүдэд эмгэгүүдэд нөлөөлөх, урьдчилан сэргийлэх үйлдэл бүхий иогийн асануудыг хийж гүйцэтгэх арга, техникийг эзэмших
42. Шим авхуулах
43. Хэвлийн туулга
44. Хамрын туулга
45. Зөөлөн шимт
46. Нируха
47. Тосон засал
48. Бусад төрлийн дэвтээлэг заслүүд
49. Хэвлийн туулга
50. Гаргалтууд хийх

ЗУРГАА. СУРГАЛТЫН АГУУЛГА

Сургалт нийт 88 долоо хоног үргэлжлэх ба заавал судлах, сонгон судлах, мэргэшүүлэх тойролтуудыг хийж гүйцэтгэсэн байна.

№	Тойролтын нэр	Долоо хоног
1.	МАУ-ны онол, Эмнэлгийн төвөд хэл	4
2.	Монгол эмийн түүхий эд	4
3.	Угсаатны анагаах ухаан судлал	4
4.	Харилцааны ур чадвар, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй / <i>Communication skills</i> /	2
5.	Эмнэлгийн хууль эрх зүй / <i>Legal Law</i> /	2
6.	Судалгааны арга зүй / <i>Research methodology</i> /	2

7.	Илтгэх ур чадварын сургалт /Presentation skills/	2
8.	Халдварын сэргийлэлт хяналт	2
9.	Өвчний ангилал зүй, оношийн код, нэр томъёо	4
10.	Монгол эмийн жор судлал	4
11.	Зурхай судлал, тарни бясалгал	4
12.	Монгол анагаах ухааны онош зүй	8
13.	Монгол анагаах ухааны засал	10
14.	Бариа засал, иог эмчилгээ	8
15.	Халуун өвчин	8
16.	Монгол анагаах ухааны дотор өвчин судлал	12
17.	Монгол анагаах ухааны өвчнөөс урьдчилан сэргийлэх ёс	4
18.	Амилуулах суурь тусламж	4
Нийт		88

ТОЙРОЛТ 1. МОНГОЛЫН АНАГААХ УХААНЫ ОНОЛ, ЭМНЭЛГИЙН ТӨВӨД ХЭЛ

1. УА-ны хөгжлийн түүхэн үе шатууд, “Анагаах ухааны дөрвөн үндэс” (АУДҮ) зохиолын агуулга, бүтэц 4 үндэс (жүд), 11 орон (най), 15 үес (гав), 4 товч (доши) хэмээх ухагдахуун
2. УА-ны тулгуур онолууд болох арга билгийн онол, таван махбодын онол, цул сав эрхтний онол, махбодын бэлгэ чанар, мөн чанар
3. Биеийн ба өвчний билгэ чанар, эрүүл ба өвчтэй биеийн мөн чанар
4. Өвчний шалтгаан, нөхцөл, орох ёс, өвчин явагдах үе шат
5. Өдөр бүрийн хийгээд цаг, ахуй үесийн явдал мөрийн тухай, өвчингүй эрүүл орших ёс
6. Дөрвөн ерөндгийн тухай ойлголт /идээ ундаа, явдал мөр, эм, засал/
7. Хөврөл тогтох бойжих ёс, долоон тамир тунгалаг цөвийн боловсролт
8. Биеийн гүйцэд хэмжээ
9. Биеийн үйл ялгал, өвөрмөц чанар

ТОЙРОЛТ 2. МОНГОЛ ЭМИЙН ТҮҮХИЙ ЭД

1. Уламжлалт анагаах ухаанд хэрэглэгддэг эмийн жор найрлагад ордог эмийн ургамлууд болон амьтан, эрдсийн гаралтай эмийн түүхий эдүүдийг зөв таньж тодорхойлох
2. Эмийн түүхий эдүүдийн нэршил (латин, төвд, монгол)
3. Эмийн түүхий эдүүдийн үйлдэл үйлчилгээ
4. Ховордож буй ургамлын генийн сан, тарималжуулалт
5. Жор эмийн үйлчилгээ болон хэрэглэх арга

ТОЙРОЛТ 3. УГСААТНЫ АНАГААХ УХААН СУДЛАЛ

1. Ахуй амьдралын нөхцөлд тулгуурласан эмчилгээний зарим аргууд
2. Идээ, ундаа эмчилгээний аргууд
3. Дом засал тархи доргилт
4. Бэртэл гэмтэл
5. Хорын өвчин
6. Нялхсын өвчинд нийцүүлсэн эмчилгээ
7. Ургамал, амьтан, эрдсийн гаралтай түүхий эдээр өвчнийг засах арга

ТОЙРОЛТ 4. ӨВЧНИЙ АНГИЛАЛ ЗҮЙ, ОНОШИЙН КОД, НЭР ТОМЬЁО

1. Өвчний тодорхойлолт, ангилал
2. Уламжлалт анагаах ухааны өвчний ангилал
3. 1-14 бүлэг ангиллын нэр, код

ТОЙРОЛТ 5. МОНГОЛ ЭМИЙН ЖОР СУДЛАЛ

1. Уламжлалт аргаар эм найруулах арга
2. Жорыг задлан шинжлэх
3. Эмийн түүхий эдүүдийн амт, чадал, үйлдэл
4. Эмэнд хөлөг, хачир хийх ёс
5. Эмийн түүхий эдийн номхотгол
6. Эмийн үйлдэл
7. Эм уух ёс, хэрэглэх заалт
8. Жорын нэршил

ТОЙРОЛТ 6. ЗУРХАЙ СУДЛАЛ, ТАРНИ БЯСАЛГАЛ

1. Зурхайн төрөл зүйл, тулгуур онолууд
2. Суудлын үүднээс өвчтөнийг (өвчнийг) шинжлэх
3. Жилийн суудал биед нөлөөлөх нөлөөлөл
4. Нашидүрсүм, гүмиг тэргүүтнийг буулгах (тооцох) ёс
5. 8 хөлөлийн тухай
6. Суудал хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх тухай
7. 9 мэнгэний тухай
8. Мэнгэ хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх
9. 12 жилийн амь, бие, эрхтэн, хийморь, сүлд махбодуудуудын эерэг, сөрөг нөлөөлөл
10. Таншин буюу өвчтөний (өвчний) зурхай

ТОЙРОЛТ 7. МОНГОЛ АНАГААХ УХААНЫ ОНОШ ЗҮЙ

1. Дан, хавсарсан, хурсан өвчний зовуурь, шаналгаа, шинж тэмдэг
2. Дан, хавсарсан, хурсан, их архаг, цул савын өвчний үед бэлчир орон болон судсанд гарах өөрчлөлтүүд
3. Уул тал завсрын халуун

4. Хий шар бадганы гурван боомт
5. Өвчний 10 их баримтлал
6. Өвчнийг шинжлэн тодруулах хэрэгт 4 товч

ТОЙРОЛТ 8. МОНГОЛ АНАГААХ УХААНЫ ЗАСАЛ

1. Зонхилон тохиолдох өвчний ханах засал
2. Зонхилон тохиолдох өвчний төөнө засал
3. Байгалийн болон хиймэл рашаан
4. Шавар эмчилгээ
5. Самнуур, шивүүр
6. Жин засал, халуун хүйтэн жин
7. Хэвлийн ба судсан туулга
8. Бөөлжүүлэх засал
9. Туулгах засал

ТОЙРОЛТ 9. БАРИА ЗАСАЛ, ИОГ ЭМЧИЛГЭЭ

1. Монгол барианы техник
2. Суваг хэрдэс, бэлчир сүв
3. Цул савд холбогдох сувгууд
4. Бариа заслын оношилгооны аргууд
5. Бариа засал эмчилгээний тасгийн зохион байгуулалт
6. Халдвар хамгааллын дэглэм

ТОЙРОЛТ 10. ХАЛУУН ӨВЧИН

1. Халуун өвчнийг ялгавартай оношлох мэдлэгээ дээшлүүлэх
2. Эс боловсорсон халуун, элэгний эмгэгийн үеийн хануур заслын үйлдлийн механизм
3. Урьдчилан сэргийлэх

ТОЙРОЛТ 11. МОНГОЛ АНАГААХ УХААНЫ ДОТОР ӨВЧИН СУДЛАЛ

1. Нэмэгдэх хасагдах өвчний орон
2. Цагаан судас болон бүлх шөрмөс, зүрх амин судас, ясанд шунасан хий зэрэг өвчнүүдийн холын, ойрын шалтгаан
3. Өвчнүүдийн нөхцөл
4. Өвчин зүйн хувиралт
5. Ангилал, оношилгоо, ялгавартай оношилгоо
6. Эмчилгээ
7. Урьдчилан сэргийлэх

ТОЙРОЛТ 12. МОНГОЛ АНАГААХ УХААНЫ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЁС

1. Өвчнөөс сэргийлэх тухай уламжлалт эмнэлгийн сургаал
2. Эрүүл болон эмгэгийн тухай ойлголт
3. Өдөр тутмын явдал мөр
4. Цагийн, ахуй үесийн явдал мөр
5. Өвчнөөс урьдчилан сэргийлэх арга
6. Идээг цээрлэх, идээний хэмжээг тохируулах ёс
7. Сэтгэл засал эмчилгээ
8. Бие махбодын өвөрмөц чанарын тухай ойлголт

ТОЙРОЛТ 13. АМИЛУУЛАХ СУУРЬ ТУСЛАМЖ

1. Яаралтай тусламжийн суурь зарчим, нэрвэгдэгчдийг эрэмбэлэх, шалтгаан, эмгэг жамыг тогтоож, эмнэл зүйн шинжийг үндэслэн оношлох;
2. Эмнэлгийн анхны яаралтай тусламж үзүүлэх
3. Сэхээний тасагт хийгдсэн лабораторийн ба багажийн шинжилгээнд дүгнэлт хийж, оношийг баталгаажуулахад шаардагдах мэдлэг чадвар эзэмших
4. Яаралтай тусламжид өргөн хэрэглэдэг эм, эмчилгээний зарчмыг мэдэх, зөв цэгцтэй, яаралтай тусламж үзүүлэх аргуудыг эзэмших
5. Амь тэнссэн үед амьсгал удирдах, тусламж үзүүлэх
6. Зүрхний шигдээс, гипертонийн криз, амьсгалын дутагдал, хордлогыг оношлох, цус алдалтыг тогтоох, хүчил, шүлтийн тэнцвэр алдагдлыг зохицуулах
7. Гаднын шалтгаантай гэмтлийн үед шаардлагатай тусламж үзүүлэх

Загвар 1.

Ажлын байрны сургалт (*On-the-Job Training*)

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Үйлчлүүлэгч/Хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Амбулаторийн үзлэг хийх	1	3 цаг 7 хоногт 2 удаа	Амбулатори	Өвчтөн	Эмнэлзүйн сургагч багш
Хяналтын тойрон үзлэг хийх	3-5	1 цаг Өдөр бүр	Тасаг	Өвчтөн	Эмнэлзүйн сургагч багш
Сургалтын тойрон үзлэг хийх	3-5 хүртэл	1 цаг 7 хоногт 1 удаа	Сургалтын ерөө, танхим	Слайд	Эмнэлзүйн сургагч багш
Гардан үйлдэл хийх	Өдөр бүр 3-5	Шаардагдах хугацаагаар	Эмчилгээний ерөө	Өвчтөн	Эмнэлзүйн сургагч багш

Загвар 2.

Танхимын сургалт (Off-the Job Training)

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Бие даалт	1	Тохиромжтой, чөлөөт цаг	Гэртээ, номын сан	Ном, интернет	Өөрөө, хамтран суралцагч эмч
Лекц	20 хүртэл	7 хоногт 2-3 удаа 1 цаг	Сургалтын анги, танхим	Слайд	Эмнэл зүйн сургагч багш, хамтран суралцагч эмч
Журнал клуб	20 хүртэл	7 хоногт 1 удаа 1 цаг	Сургалтын анги, танхим	Слайд, эрдэм шинжилгээний өгүүлэл	Эмнэл зүйн сургагч багш, хамтран суралцагч эмч
Эмнэлзүй ба МУАУ судлалын хурал	20 хүртэл	Товлогдсон хугацаанд 1-3 цаг	Хурлын танхим	Тохиолдлын танилцуулга	Эмнэл зүйн сургагч багш

Загвар 3.

Үйл ажиллагааны хуваарь

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
~ 8:30	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг	Ганцаарчилсан үзлэг
9:00-11:00	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Хяналтын тойрон үзлэг
11:00-13:00	Лекц, семинар	Амбулаторийн үзлэг	Лекц, семинар	УАУ эмнэлэг-тасаг, Уламжлалт эмийн үйлдвэр Уламжлалт эмийн үйлдвэр	Амбулаторийн үзлэг
13:30-14:00		УАУ эмнэлэг-тасаг, Уламжлалт эмийн үйлдвэр		Журнал клуб	УАУ эмнэлэг-тасаг, Уламжлалт эмийн үйлдвэр
14:00-15:00	Симуляци (дуураймал орчин)		Сургалтын тойрон үзлэг		
15:00-17:00	Бие даалт	Бие даалт	Бие даалт	Бие даалт	Бие даалт

ДОЛОО. ҮНЭЛГЭЭ, ЭРГЭН ЗӨВЛӨГӨӨ

7.1. Суралцагч эмч ба хариуцагч

Сургалтын 2 жилийн хугацаанд суралцагч эмч бүрт хэрхэн ахин дэвшиж байгаа, хэрхэн сайжруулах тухай эргэн зөвлөгөө өгөх, суралцагч эмчийн хувийн төлөвлөгөөний (*career plan*) талаар зөвлөлдөх, тэднийг хариуцан ажиллах хүн (*mentor*) цаашид “хариуцагч” гэх)-ийг оноож хуваарилна. Суралцагч эмч нь сургалт эхлэх үед хариуцагчтай уулзах ба цаашид 2-3 сар тутамд 1 удаа уулзаж ярилцан, үнэлгээтэй танилцаж, эргэн зөвлөгөө авна.

7.2. Суралцагч эмч ба эмнэл зүйн сургагч багш

Суралцагч эмчийн тойролт бүрт сургалт удирдах эмнэл зүйн сургагч багш оноож хуваарилна:

- Суралцагч эмч нь тухайн тойролт эхлэхээс өмнө эмнэл зүйн сургагч багштай уулзаж, тойролтын хугацаанд тавьсан зорилтоо ярилцана.
- Суралцагч эмч нь тойролтын явцад тавьсан зорилтод хүрэхийн тулд дутагдаж байгаа зүйл, түүнийг нөхөхөд хэрэгцээтэй байгаа зүйлийн тухай эмнэл зүйн сургагч багштай ярилцана.
- Суралцагч эмч нь тойролт дуусахад эмнэл зүйн сургагч багштай ярилцлага хийж, сургалттай холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө авна.

7.3. Үнэлгээний арга

7.3.1. Төгсөлтийн шалгалт

“Монголын уламжлалт анагаах ухаан судлал”-ын үндсэн мэргэшлийн сургалтын төгсөлтийн шалгалт өгнө. Шалгалтад тэнцсэн тохиолдолд “Монголын уламжлалт анагаах ухаан судлаач эмч”-ийн үнэмлэх олгоно.

7.3.2 Ажлын байранд-суурилсан үнэлгээ (*Workplace-based Assessment*)

360 хэмийн үнэлгээ (*360-Degree Assessment*):

Суралцагч эмчийн мэргэжлийн байх (*professionalism*) болон зохион байгуулагч, манлайлагч (*leader*) байх зэргийг үнэлэхэд хэрэглэнэ. 2 жилийн сургалтын дунд үе болон төгсөх үед хийнэ. Тойролтыг удирдсан эмнэл зүйн сургагч багш, сувилахуйн мэргэжилтэн, тухайн тасаг, нэгжийн хамтран ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, өвчтөн зэрэг нийт 5 хүн тус тусдаа үнэлнэ. Үнэлгээ хийх хүнийг сургалтын албанаас сонгоно. Үнэлгээний дүнг суралцагч эмч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэсэн эргэн зөвлөгөөг хариуцагчаас суралцагчид өгнө.

Mini-CEX/Эмнэл зүйн дасгал үнэлгээ (Mini-Clinical Evaluation Exercise):

Зайлшгүй таньж мэдэх 12 шинж тэмдгээс тойролт бүрт 12-оос доошгүй шинж тэмдгийг тус бүр 5-аас доошгүй удаа, нийт 10-аас доошгүй удаа үнэлгээ хийнэ. Өөр тойролтод ижил шинж тэмдгээр үнэлгээ хийсэн ч болно.

Үнэлгээ хийх эмчийг эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг, нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч эмч өөрөө сонгох ба тухайн сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж, цаашид хэрхэн сайжруулах зөвлөгөө заавал өгнө.

Гардан үйлдлийн ур чадварын шууд ажиглалт/DOPS (Direct Observation of Procedural Skills):

Зайлшгүй сурах 50 гардан үйлдлээс 50-аас доошгүйг хийж чаддаг болсныг эмнэл зүйн сургагч багш нотолж, баталгаа өгөх хүртэл давтан үнэлгээ хийнэ.

Үнэлгээ хийх эмчийг эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг, нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч эмч өөрөө сонгох ба тухайн сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж, цаашид хэрхэн сайжруулах зөвлөгөө заавал өгнө.

Портфолио үнэлгээ (Portfolio Assessment):

Суралцагч эмч нь сургалтын хугацаанд суралцсан лекц, эмгэг судлалын тусламж үйлчилгээний сургалтын үеэр эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа хийсэн материал зэрэг сургалттай холбоотой бусад бичиг баримтыг үр дүн болгож хадгална.

7.4 Үнэлгээний дүнг хянах

- 360-хэмийн үнэлгээний дүнг сургалтын алба хяналт тавьж, хадгална. Үнэлгээний дүнг суралцагч эмч, хариуцагчид танилцуулах ба бусадтай хуваалцахгүй байхыг анхааруулна.
- Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг суралцагч эмч өөрөө хадгална.
- Портфолиод үнэлгээ, эмнэл зүйн сургагч багштай зөвлөлдсөн асуудал, өгсөн зөвлөгөөг бичиж тэмдэглэн хадгална.
- Суралцагч эмч нь тойролт бүрийн төгсгөлд Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг сургалтын албанд хүлээлгэн өгнө.
- Сургалтын алба үнэлгээний дүнг сургалтын хяналтын зөвлөлд танилцуулах ба сургалтын төгсгөлд хариуцагчаас суралцагч эмчид зөвлөгөө өгнө.

7.5 Сургалтын төгсөлтийг шийдвэрлэх

- Тойролт бүрт хийгдсэн Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг нэгтгэсний үндсэн дээр суралцагч эмчийг тухайн тойролтыг төгсгөх эсэх шийдвэрийг сургалтын хяналтын зөвлөл гаргана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь тойролт бүрт хийгдсэн Mini-CEX болон DOPS үнэлгээний дүн, 360 хэмийн үнэлгээний нэгдсэн дүн, суралцагчийн

сургалтын ирц, зайлшгүй таньж мэдэж суралцах шинж тэмдэг, өвчний тохиолдол, гардан үйлдлийн тоог харгалзан сургалтын төгсөлтийн эцсийн шийдвэрийг гаргана. Шийдвэр гаргах шалгуур нь:

- Зайлшгүй сургалтад оролцсон байх өдрийн тоо буюу сургалтын ирц: Хөдөлмөрийн тухай хуульд заасан цалинтай амралтын өдрийн тоо, хүндэтгэх шалтгаантай авах амралтын өдрийн тоог оруулаад сургалтын хугацаанд авах амралтын өдрийн тоог сургалтын тойролт тус бүрийн нийт өдрийн 20%-аас хэтрүүлэхгүй байна. Сургалтын ирц хангалтгүй бол тухайн тасарсан сургалтын өдөр, агуулгыг нөхүүлнэ.
- Зайлшгүй таньж мэдэх шаардлагатай шинж тэмдгээс 12 оношилж, эмчлэн туршлага хуримтлуулсан байна.
- Зайлшгүй туршлага хуримтлуулсан байх шаардлагатай өвчний тохиолдлын тоо нь 80-аас доошгүй удаа үзэж, туршлага хуримтлуулсан байна.
- Зайлшгүй суралцах 50 гардан үйлдлээс 1 жилийн турш 20-аас доошгүйг хийж гүйцэтгэн, туршлага хуримтлуулсан байна
- Тойролт бүрийн төгсгөлд эсвэл 1 жилийн сургалтын эцэст суралцагчийг төгсгөх боломжгүй гэсэн шийдвэр гарсан тохиолдолд шалтгаан, цаашид сургалтыг хэрхэн төгсгөх талаарх шийдвэр, зөвлөмжийг сургалтын алба болон хариуцагчаас тухайн суралцагч эмчид тайлбарлаж өгнө.

НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ, ХЯНАЛТ

8.1 Сургалтын хяналтын зөвлөл

- Сургалтын албаны мэргэжилтэн, эмгэг судлалын тусламж үйлчилгээний албаны дарга, “Монголын уламжлалт анагаах ухаан судлал” үндсэн мэргэшлийн хөтөлбөрийн тойролт хариуцсан багш, байгууллагын захиргааны албаны төлөөлөл, суралцагч эмчийн төлөөллөөс бүрдэнэ. Сургалтын хяналтын зөвлөл нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллагын захирлын шууд удирдлага дор ажиллана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь улирал бүр хуралдана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь суралцагч эмчийн сургалт, тулгарсан асуудалтай танилцах, суралцагч эмчтэй холбоотой асуудлыг ярилцаж шийдвэрлэх арга замыг судалдаг бүтэц байна.
- Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүд нь сургалтыг илүү сайжруулахын тулд өөрийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэхийг зорьж ажиллана.

8.2 Хөтөлбөрийн хяналт

- Сургалтын алба хөтөлбөрт хяналт хийнэ.
- Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, эмнэлзүйн сургагч багшид чиглэсэн сургалт (*Faculty development*),

суралцагч эмчийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.

- Хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд сургалтын хяналтын зөвлөлд оруулж хэлэлцүүлэн, өөрчлөлт хийнэ. Энэ тухай эрүүл мэндийн хөгжлийн төвд албан бичгээр ажлын 10 хоногт багтаан мэдэгдэнэ.

8.3 Сургалтын танилцуулга (*Orientation*)

Сургалт эхлэхийн өмнө тойролт бүрийн сургалтын төлөвлөгөө болон хөтөлбөрийн агуулгын уялдааг тодорхой ойлгох, сургалт эрхлэх байгууллага, түүний үйл ажиллагаа, эмчилгээ, оношилгооны аюулгүй байдал, халдвар хамгааллын тухай суралцагч эмчид гүнзгий ойлголт өгөх зорилго бүхий танилцуулга хичээлийг зохион байгуулна.

360 ХЭМИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Суралцагч эмчийн нэр: _____

Үнэлгээ хийгч: Эмнэл зүйн сургагч багш Сувилагч Бусад _____

Суралцагч эмчийг ажигласны үндсэн дээр, бусдаас сонссон, мэдсэн зүйл дээр бус, суралцагч эмчийн зан үйлийг хэр давтамжтай байсныг өөрийнхөө ажигласнаар оноо тавина уу.

<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Үнэлэх боломжгүй	Ховор (≤ 19)	Заримдаа (20-49%)	Ихэнхдээ (50-79%)	Бараг бүгд ($\geq 80\%$)

Өвчтөн/гэр бүлийн хувийн асуудлыг хүндэтгэдэг	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Эмнэлгийн бичиг баримтыг бүрэн гүйцэт, гаргацтай, цаг хугацаанд нь хөтөлдөг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Орон нутгийн хүн амын эрүүл мэндийн асуудалд өөрийн санаачилгаар хувь нэмрээ оруулдаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Өвчтөний бие даасан байдлыг хүндэтгэж, өвчтөнд тохирсон хамгийн зөв шийдвэрийг гаргахад хичээн зүтгэл гаргадаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөнийг хүндэтгэж эмчилдэг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Өөрийн эмнэл зүйн ур чадварыг дээшлүүлэхийн тулд сургалт болон бусад боломжийг алдалгүй ашигладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Өөрийн уламжлалт анагаах ухааны онолын мэдлэгээ дээшлүүлэхийн тулд бие даан суралцдаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Орон нутаг дахь бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран ажилладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Эмнэлэг доторх бусад эмч, мэргэжилтэнтэй хамтран ажилладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Орон нутгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйг ухамсарладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4
Эмнэлэг доторх тусламж, үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйгээ ухамсарладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4

1 эсвэл 4 оноо тавьсан бол тухайн асуултын дагуу саналаа бичнэ үү.

--

Дүгнэлтийг тодорхой бичих хэрэгтэй. Жишээ нь: "Тэр бол найдваргүй" гэх нь тодорхой биш. Илүү хэрэг болох дүгнэлт бол: "Тэр сүүлийн 3 удаагийн журнал клубийн 2-т нь хэн нэгэнд урьдчилан мэдэгдэлгүйгээр оролцсонгүй."

Өөрөөсөө асуу: "Миний дүгнэлт цаашид сайжрахад нь суралцагч эмчид хэрэг болох уу?"

ЯВЦЫН MINI-СЕХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Он, сар, өдөр _____ / _____ / _____

Суралцагч эмчийн нэр: _____

Үнэлэгчийн нэр: _____

Сургалт эрхлэх байгууллага: _____ Нэгж: _____ Газар: Амбулатори
 Эмийн үйлдвэр УА тасаг Бусад _____ Өвчтөний нас: _____ Хүйс: Эр Эм

Өвчтөний зовуурь: Халуурах Шарлах Толгой өвдөх Ухаан санааны байдал өөрчлөгдөх Татах Ханиалгах Цээжээр өвдөх Дотор муухайрах, бөөлжих, Хоосон огих Хэвлийгээр өвдөх Суулгах Нуруу өвдөх Саажих Хавагнах Үе өвдөх Зүрх зогсох Жихүүцэх Эвшээх, суниах Таван мэдрэхүй үл тодрох Сэтгэл санаа тогтворгүй болох Сүүж бэлхүүс, яс үесээр хатгуулж өвдөх Энд тэндгүй тогтворгүй өвдөх Идээ шингэсний дараа, өглөө үүрээр, үдшийн бүрийд өвчин хөдлөх Аманд гашуун амт амтагдах Идээ шингэх үед өвдөх Хоолонд дургүй болох Бусад

Сайн талууд	Сайжруулахад чиглэсэн зөвлөгөө	Бусад

Сургалтын тухайн үед суралцагч эмчийг ямар түвшинд байгааг ажигласнаа үнэлнэ үү.

Бодит үзлэг хийх шаардлагагүй тохиолдолд тэмдэглэнэ үү

Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай
Өвчний түүх авах			
Бодит үзлэг			
Оношилгоо, эмчилгээний менежмент			
Харилцааны ур чадвар			
Эмнэл зүйн ерөнхий чадвар			

Сайжруулахын тулд зөвшилцөж биелүүлэх үйлдэл

Үнэлэгчийн гарын үсэг _____ Суралцагч эмчийн гарын үсэг _____

"Хангалттай" гэж тодорхойлоход хэрэглэх үзүүлэлт	
Өвчний түүх авах	<ul style="list-style-type: none"> • ялган оношилгоо хийхүйц дэлгэрэнгүй асуумж авдаг • өвчтөний хэрэгцээг илрүүлж, хариу үзүүлдэг. • өвчтөний дохио зангааг ойлгож, тохиромжтой хариу үзүүлдэг.
Бодит үзлэг	<ul style="list-style-type: none"> • ялган оношилгоо хийхүйц дэс дараалсан бодит үзлэг хийдэг. • үзлэгийн үед өвчтөнд таатай байдал бүрдүүлэхэд анхаардаг.
Эмнэл зүйн менежмент	<ul style="list-style-type: none"> • зөв онош тавьдаг • оношилгоо, эмчилгээнд шаардлагатай шинжилгээ төлөвлөж, үр дүнг ашигладаг. • тохирсон эмчилгээг эхлүүлдэг.

	<ul style="list-style-type: none"> • тохирсон тасаг, эмнэлэгт шилжүүлдэг, цааш нь хяналт тавьдаг.
Харилцааны ур чадвар	<ul style="list-style-type: none"> • өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл садны хүнийг сайн сонсдог. • өвчтөн, түүний гэр бүл, амран хамгаалагч, төрөл садны хүнтэй эелдэг энгийн үг хэллэг хэрэглэж харилцдаг • өвчтөн, түүний гэр бүл, амран хамгаалагч, төрөл садны хүний зовнилыг хуваалцаж, хүндэтгэлтэй ханддаг.
Эмнэл зүйн ерөнхий чадвар	<ul style="list-style-type: none"> • Системтэй (харилцан уялдаатай) арга замыг тодорхойлдог. • өвчтөний таатай, аюулгүй байдлыг хангахад тодорхой идэвх зүтгэл гаргадаг • би гэр бүлийнхээ хэн нэгнийг энэ эмчээр эмчлүүлэхийг зөвшөөрч чадна!

ГАРДАН ҮЙЛДЛИЙН УР ЧАДВАРЫН ШУУД АЖИГЛАЛТ (DOPS)-ЫН ҮНЭЛГЭЭ

Он,сар, өдөр _____ / _____ / _____

Суралцагч эмчийн нэр: _____

Үнэлэгчийн нэр: _____

Сургалт эрхлэх байгууллага: _____ Нэгж: _____ Газар: Амбулатори Эмийн үйлдвэр УА тасаг Бусад _____

Гардан үйлдэл: Амилуулах суурь тусламж, зүрх уушгины сэхээн амьдруулалт
 Тариа хийх (судас тариа, булчин тариа, арьсан дор) Зүрхний цахилгаан бичлэг хийх
 Цусан дахь сахарын хэмжээг тодорхойлох Ханах заслын холын бэлтгэл хийх
 Ханах заслын ойрын бэлтгэл хийх Хануурын боолт хийх Ханах засал хийх
 Уул өвсөн төөнө хийх Харандаан төөнө хийх Эмч бодисын төөнө хийх (Монгол төөнө)
 Зүүлэх төөнө засал хийх Хайрцган төөнө хийх Шовгон төөнө хийх
 Хатгуур засал хийх Бүлээн зүү засал хийх Сам соруул засал хийх Соруул засал хийх
 Шивүүр засал хийх Усан дэвтээлэг засал хийх Ороож боох дэвтээлэг хийх
 Илж нухлах засал хийх Шимжүүлэх бариа хийх Жин засал хийх

Одоог хүртэл суралцагч эмчийн тухайн гардан үйлдлийг хийсэн тоо _____

Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай	Ажиглагдаагүй/ үнэлэх боломжгүй
Хийх гэж буй үйлдлээ өвчтөнд тайлбарладаг. Өвчтөнөөс зөвшөөрлийн хуудас авдаг.				
Гарлан үйлдэл хийх бэлтгэлийг зохистой хийдэг.				
Халдваргүйжүүлэх үйлдлийг гүйцэтгэдэг, багаж хэрэгслийг аюулгүй хэрэглэдэг.				
Арга техникийг чадварлаг гүйцэтгэдэг.				
Өөрийн чадахгүй үйлдлийг ойлгож, шаардлагатай үед тусламж дууддаг.				
Багаж хэрэгсэл, материалыг цэвэрлэдэг				
Шаардлагатай бичиг баримтыг гүйцэт бичдэг.				
Гардан үйлдэл хийх ерөнхий чадвар				

Зөвлөмж:

- Сайн тал:

- Сайжруулах тал:

Бусад санал:

Сайжруулахын тулд зөвшилцөж, биелүүлэх үйлдэл:

Үнэлэгчийн гарын үсэг: _____

Суралцагч эмчийн гарын үсэг: _____

НОМ ЗҮЙ:

Тойролт-1

Үндсэн:

1. Д.Цэнд-Аюуш, Т.Алимаа, Ч.Батнайрамдал “Монгол анагаах ухааны онол” “Мөнхийн үсэг” ХХК. 2017 он
2. Х.Тумбаа “Анагаах ухааны дөрвөн үндэс”(хөрвүүлсэн) Улаанбаатар 1991
3. Ютиг Ёндонгомбо “Сориг жүд ши” Монгол хадмал хэвлэл, Өвөр Монголын үндэстний хэвлэлийн хороо, I,II боть.Хөх хот 1991 он
4. Ч.Батнайрамдал “Төвөд хэл сурах бичиг” Биттрейд, 2016
5. Ламын гэгээн Лувсанданзанжанцан (1689) “Үрийн зурхайн сайн номлол бүхний хураангуй” Төвөд хэлнээс орчуулсан Л.Тэрбиш УБ. 1991 он.
6. Лувсанбалжор (1908). “Таван хураангуй махбодын барилдлага тэргүүтний үрийн номлол онц гайхамшигт болор толь” Төвөд хэлнээс орчуулсан Л.Тэрбиш. УБ. 2000 он 3-132 х
7. Цахар гэвш Лувсанцүлтим Махбодын зурхайн ёсны жилийн гайг шинжлэх увдис утгын хураангуй” Төвөд хэлээр бичигдсэн модон барын судар

Нэмэлт:

1. Д.Мөнх-Очир “Монгол зурхайн түүхэн товчоон” УБ. 2006. 317 х.
2. Ш.Агваандондов Хүний жил сар өдөр цагийн төөрөг оршвой.УБ.1992.67 х.
3. Б.Батжаргал “Монгол зурхай буюу эртний Монгол математик” УБ.1990.62 х
4. Д.Мөнх-Очир “Зурхайн түүвэр толь” УБ.2006.5-359х
5. Балжорравдан “Өлзий хутгийн сайн найлзуур модон” орчуулсан Даваасүрэн. Д УБ.2008 он х 8,13,20,21,25
6. С.Сээсрэгдорж “Тэжээхүйн ухаан дахь эрүүл аж төрөх их өв соёл” УБ.2012

Тойролт-2

1. У. Лигаа. Монгол орны эмийн ургамлыг өрнө дорны анагаах ухаанд хэрэглэхүй. УБ. 2005.
2. Б.Дагвацэрэн. Г.Наранцэцэг. Ургамлын эмийн зохистой хэрэглээний гарын авлага. УБ. 2005.
3. Б. Хүрэлчулуун, Д. Суран. Монгол эмэнд хэрэглэдэг ургамлын түүхий эдийн зурагт лавлах . УБ.2007.
4. Б. Хүрэлчулуун, Ө. Батчимэг. Монгол орны ургамлын гаралтай зарим эмийн түүхий эдийн лавламж. УБ. 2006.
5. Б.Хүрэлчулуун, Ө.Батчимэг. Монгол эмэнд хэрэглэгддэг гадаад ургамлын түүхий эд. УБ.2004
6. Б. Пүрэвсүрэн, З. Мэндсайхан. Монгол эмийн эрдэс чулуу. УБ. 2002.
7. Ц. Хайдав, Ц. Ширхан. Монгол ардын эмнэлэгт хэрэглэгдэж байсан зарим эрдэс. УБ. 1975.
8. Ц. Хайдав. Ардын эмнэлэгт хэрэглэгддэг амьтны гаралтай эм. I, II боть. УБ. 1977-1982.

9. Ч. Баавгай, Б. Болдсайхан. Монголын Уламжлалт Анагаах Ухаан. УБ. 1980.
10. Олдох С. Цэрэнцоо Б. Батхуяг П. "Монгол эмийн судлал" УБ 2017
11. Ганбаяр Я. "Монгол эмийн жорын гарын авлага". УБ. 2001

Тойролт-3

Үндсэн:

1. ШУА, Түүхийн хүрээлэн. "БНМАУ-ын Угсаатны зүй-1". УБ.1987 он
2. Д.Насанбуян. "Монгол эм домын засал". УБ. 1991 он
3. Ч.Баатар. "Ардын эмчилгээ". УБ. 1998 он
4. Д.Баттогтох. "Эмгэг согог бүхнийг эдгээн илааршуулагч эм, дом, засал төөнө, зурхай оршвой". УБ. 1996 он
5. Б.Тогоо. "Монгол эмнэлгийн засал". УБ. 1991 он
6. С.Баяндорж. "Хар домын судар". УБ. 1990 он

Нэмэлт:

1. Ч.Мөнхбаяр, Н.Батжаргал. "Сүлд хийморийн монгол домын гайхамшиг". УБ. 2004 он
2. Р.Байгалмаа. "Нийгмийн эрүүл мэнд ба бие, хэл, сэтгэлийн ариусгал". Өндөрхаан. 2012 он
3. Пол Брэгг. "Эрүүлжих ухаан, эмгүй амьдрал". Хөрвүүлсэн О.Чинзориг. УБ. 2004 он
4. Х.Отгонбилэг. "Мэргэн ардын мэдүүштэй арга". УБ. 2004 он
5. Анагаах арга билэг. "Мянган өвчнийг анагаах арга". УБ. 2004 он
6. Ж.Жамсран. "Залуужуулж урт наслуулах увидас ухаан". УБ. 1994 он

Нэмэлт сурвалжууд

1. <https://ethnomed.org/>
2. <https://ethnobiomed.biomedcentral.com/>
3. <https://www.wiley.com/en-us/Ethnopharmacology-p-9781118930748#:~:text=Ethnopharmacology%20is%20one%20of%20the,the%20development%20of%20new%20drugs.>
4. <https://www.journals.elsevier.com/journal-of-ethnopharmacology>

Тойролт-4

1. АУДҮ-ийн онолын үндэс, язгуурын үндэсний өвчний ангилал
2. Дармо маарамба Лувсанчойдог. Алтан хадмал
3. Дармо маарамба Лувсанчойдог. Алтанчимэг
4. Дэсрид Санжаажамц. Манаг Лхантав
5. Ишбалжирын Дөрвөн рашаан
6. Ганбаатар Одонцэцэг. Уламжлалт анагаах ухаан дахь өвчний ангиллын судалгаа. Анагаах ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. 2016 он.
7. International Statistical Classification of Diseases and Related Health Problems, Tenth Revision, ICD -10, 11

8. International Classification of Functioning Disability, ICF
9. WHO releases new International Classification of Diseases (ICD 11)
10. ICD-11 will be presented at the World Health Assembly in May 2019 for adoption by Member States, and will come into effect on 1 January 2022. This release is an advance preview that will allow countries to plan how to use the new version, prepare translations, and train health professionals all over the country.
11. ICD-11. International Classification of Diseases for Mortality and Morbidity Statistics. Eleventh Revision. Reference Guide

Тойролт-5

1. Ганбаяр Я. “Монгол эмийн жорын гарын авлага”. УБ. 2001
2. Дармаманрамба Лувсанчойдог. “Алтан хадмал”. Хөх хот. Монгол бичгээр. 1999.
3. Дармаманрамба Лувсанчойдог. “Бэрх оньсны очир зангилаа тайлагч”.
4. “Дундад улсын нэвтэрхий толь”. Хөх хот. 1985
5. Лигаа У.”Монголын уламжлалт эмнэлэгт эмийн ургамлыг хэрэглэх арга”1.2 боть 1996.1997.
6. Лувсан Б. “Монгол эм судлал”. Хөх хот. 1988
7. Лувсанчоймбол. “Тус амгалангийн шимийн хураангуй “
8. Олдох С. Цэрэнцоо Б. Батхуяг П. “Монгол эмийн судлал” УБ 2009
9. Сүрэнжав Ч. “Монгол анагаах ухааны эм найрлагын судлал”. Хөх хот 1986
11. Чойжамц. “Маш гайхамшигт хуримын сан”. Төвд хэлнээс орчуулсан Д. Балгансүрэн. УБ 1994.
12. Юй Чин Шиан “ Монгол эмийн жор” УБ 1992
13. Ютиг Ёндонгомбо. “Анагаах ухааны дөрвөн үндэс”. Хөрвүүлсэн Тумбаа Х.УБ. 1991
14. Давгацэрэн. Б нар Уламжлалт эмт бодис жорын хяналтын лавламж УБ 2014

Тойролт-6

Үндсэн:

1. Ламын гэгээн Лувсанданзанжанцан (1689) “Үрийн зурхайн сайн номлол бүхний хураангуй” Төвөд хэлнээс орчуулсан Л.Тэрбиш. УБ. 1991 он.
2. Лувсанбалжор (1908). “Таван хураангуй махбодын барилдлага тэргүүтний үрийн номлол онц гайхамшигт болор толь” Төвөд хэлнээс орчуулсан Л.Тэрбиш. УБ. 2000 он. (3-132-р тал).
3. Цахар гэвш Лувсанчүлтим “Махбодын зурхайн ёсны жилийн гайг шинжлэх увдис утгын хураангуй” Төвөд хэлээр бичигдсэн модон барын судар

Нэмэлт:

1. Д.Мөнх-Очир “Монгол зурхайн түүхэн товчоон” УБ. 2006. 317 х.
2. Ш.Агваандондов Хүний жил сар өдөр цагийн төөрөг оршвой УБ.1992. 67 х
3. Б.Батжаргал. Монгол зурхай буюу эртний Монгол математик УБ.1990. 62 х
4. Д.Мөнх-Очир “Зурхайн түүвэр толь” УБ.2006.5-359 х

5. Балжорравдан “Өлзий хутгын сайн найлзуур модон” орчуулсан Даваасүрэн Д. УБ.2008.тал 8,13,20,21,25
6. С.Сээсрэгдорж.”Тэжээхүйн ухаан дахь эрүүл аж төрөх их өв соёл”.УБ. 2012

Тойролт-7

1. Анагаах ухааны дөрвөн үндэс. Хөх хот, Үндэсний хэвлэлийн хороо. Дээд дэвтэр. 1991 /уйгаржин төвд хадмал/
2. Д.Цэрэндагва, Б.Балдансамбуу. МУАУ-ы дотор өвчний онош зүй. Улаанбаатар, 2003.
3. С.Сээсрэгдорж, Ч. Чимэдрагчаа, С.Хишигжаргал, Д.Цэрэндагва, Д.Чулуунчимэг. Монголын уламжлалт анагаах ухааны өвчнийг анагаах увдис. Улаанбаатар, 2005.
4. Ү.Байгалмаа. Монголын уламжлалт анагаах ухааны оношилгоо. Улаанбаатар, 2006.
5. З.Мэндсайхан, Б.Пүрэвсүрэн. Уламжлалт эмнэлгийн оношилгооны аргууд. Улаанбаатар, 1996.
6. Д.Нацагдорж, Г.Одонцэцэг. Онош зүй. Улаанбаатар, 2014.
7. Дарам маарамба Лувсанчойдог. Бэрх оньсны учир зангилааг тайлагч. ӨМӨЗО, Хөх хот, Ардын хэвлэлийн хороо, 1998.
8. Дарам маарамба Лувсанчойдог. Зарлигийн эрхэс харанхуйг арилгагч зул. ӨМӨЗО, Хөх хот, Ардын хэвлэлийн хороо, 1998.
9. Сурхарва Лодойжалба. Дээдсийн таалал. ӨМӨЗО, Хөх хот, Ардын хэвлэлийн хороо, 1998.
10. Ишбалжир. Дөрвөн рашаан. ӨМӨЗО, Хөх хот, Ардын хэвлэлийн хороо, 2014.
11. Лүнриг дандар. Арүрийн эрхэс. ӨМӨЗО, Хөх хот, Ардын хэвлэлийн хороо, 2014.

Тойролт-8

1. Н.Оюунцэцэг, Д.Цэнд-Аюуш, Н.Төмөрбаатар, Т.Алимаа, “Монгол анагаах ухааны засал” Улаанбаатар, 2017
2. Ютиг Ёндонгомбо. “Анагаах ухааны дөрвөн үндэс” Хөрвүүлсэн Х.Тумбаа. 1990 он. 16-18-р бүлэг /уйгаржин кирилл/
3. Дарам маарамба Лувсанчойдог “ Алтан хадмал” 2-р дэвтэр 16-р бүлэг
4. Б.Дагданбазар Монгол хануурын увьдас, УБ.1995
5. Д.Цэрэндагва “Ханах засал”, УБ. 2004
6. С.Сээсрэгдорж “Монголын уламжлалт анагаах ухааны өвчнийг анагаах увьдис” УБ. 2012
7. С.Зина, М. Мягмаржав. “Таван засал” /хөрвүүлсэн/, УБ 1995

Тойролт-9

1. А.Хиранмаяананда. Иогоор өөрийгөө анагаахуй. УБ, 2015
2. Н.Занди. Иогийн гарын авлага. УБ, 2019
3. Шри Шри Рави Шанкар. “Патанжали иогийн судар”. УБ, 2015

4. Шри Шри Рави Шанкар. "Аштавакра Гита". УБ, 2016 он
5. Swami Satyananda Saraswati. Asana pranayama mudra bandha. India, 2006
6. Sivananda yoga Vedanta center. Yoga Mind Body, Great Britain, 1996

Тойролт-10

Үндсэн:

1. Х.Тумбаа "Анагаах ухааны дөрвөн үндэс" (хөрвүүлсэн) Улаанбаатар 1990
2. Дэсрид Санжаажамц "Манаглхантав" Төвөд, Уйгаржин, Хөх хот 1992, Үндэсний хэвлэлийн хороо, х 163-195
3. Дарма маарамба Лувсан чойрог "Алтанчимэг" Хөх хот, Ардын хэвлэлийн хороо 1988, х256-299
4. Чоймбол тойн. Жүдүйниннор, Хөх хот 1999, Ардын хэвлэлийн хороо х77-81
5. Б.Болдсайхан "Буддын сургааль ба шинжлэх ухаан" УБ.2003 он, х382-395
6. Дарма маарамба Лувсанчойрог "Алтан хадмал" Хөх хот, доод дэвтэр, 1984, Ардын хэвлэлийн хороо, х1110-1128
7. С.Сээсрэгдорж, Ч.Чимэдрагчаа, С.Хишигжаргал, Д.Цэрэндагва, Д.Чулуунчимэг "Монголын уламжлалт анагаах ухааны өвчнийг анагаах увдис" УБ 2016, х 47-51

Нэмэлт:

1. Дараммаарамба Лувсанчойдог "Бэрх оньсны учир зангилааг тайлагч" /судас, шээс шинжлэх ёсны бүлэг/
2. "Харанхуйг арилгагч зул" Монгол бичиг Хөххот /судас, шээс шинжлэх ёсны бүлэг/
3. Дараммаарамба Лувсанчойрог "Алтан хадмал" Монгол бичиг /Орших ёсны бүлэг/
4. Болдсайхан "Буддын сургаал ба шинжлэх ухаан" /Халуун хүйтэн өвчний завсарыг ялган таних ёсны бүлэгт хийсэн шинжлэл/ УБ. 2003.
5. Д.Цэрэндагв, М.Амбага, Н.Төмөрбаатар, Б.Саранцэцэг, Ц.Нарантөгс "Ханах засал" УБ. 2003.
6. Ч.Чимэдрагчаа Н.Төмөрбаатар, Х.Цагаантогоо "Халуун боловсруулах үйлдлийн биологи-анагаах ухааны тайлал"УБ.2011.
7. С.Сайнсайхан "Уламжлалт анагаах ухааны онолын бие, хэл, сэтгэлийн нэгдмэл чанарын асуудлын харьцуулсан судалгаа" Магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. УБ. 2013.

Тойролт-11

1. Х.Тумбаа "Анагаах ухааны дөрвөн үндэс" (хөрвүүлсэн) Улаанбаатар 1990 он
2. Дэсрид Санжаажамц "Манаглхантав" Төвөд, Уйгаржин, Хөх хот 1992, Үндэсний хэвлэлийн хороо

3. Ишбалжир “Дөрвөн рашаан” Уйгаржин, хөх хот, 1998 он Ардын хэвлэлийн хороо
4. Дармамаарамба Лувсан чойрог “Алтанчимэг” Хөх хот, Ардын хэвлэлийн хороо 1988
5. Чоймбол тойн. Жүдүйниннор, Хөх хот 1999, Ардын хэвлэлийн хороо
6. Дармамаарамба Лувсанчойдог “Зарлигийн эрхэст харанхуйг арилгагч зул” Хөх хот, 1998, Ардын хэвлэлийн хороо
7. Дармамаарамба Лувсанчойдог “Алтан хадмал” Хөх хот, доод дэвтэр, 1984, Ардын хэвлэлийн хороо
8. Чойжамц “Маш гайхамшигт хуримын сан” УБ 1991 он
9. С.Сээсрэгдорж, Ч.Чимэдрагчаа, С.Хишигжаргал, Д.Цэрэндагва, Д.Чулуунчимэг “Монголын уламжлалт анагаах ухааны өвчнийг анагаах увдис” УБ 2016
10. Ч.Сүрэнжав “Монгол анагаах ухааны эмчилгээний судлал” Хөх хот, 1999, Ардын хэвлэлийн хороо
11. Д.Цэрэндагва, Б.Балдансамбуу. МУАУ-ы дотор өвчний онош зүй. Улаанбаатар, 2003.
12. Ү.Байгалмаа. Монголын уламжлалт анагаах ухааны оношлогоо. Улаанбаатар, 2006.
13. Дарам маарамба Лувсанчойдог. Бэрх оньсны учир зангилааг тайлагч. ӨМӨЗО, Хөх хот, Ардын хэвлэлийн хороо, 1998.
14. Сурхарва Лодойжалба. Дээдсийн таалал. ӨМӨЗО, Хөх хот, Ардын хэвлэлийн хороо, 1998.
15. Лүнриг дандар. Арүрийн эрхэс. ӨМӨЗО, Хөх хот, Ардын хэвлэлийн хороо, 2014.

Тойролт-12

1. Ютиг Ёндон гомбо. “Анагаах ухааны дөрвөн үндэс”. Төвөд- Монгол хадмал хэвлэл. Хөх хот. 1992 он. I, II боть.
2. Д.Цэнд-Аюуш, Т.Алимаа, Б.Цэрэнцоо, Ч.Батнайрамдал, Б.Баярмаа ” Монголын уламжлалт анагаах ухааны онол” УБ. “Мөнхийн үсэг” ХХК. 2017. 27.5 хх.
3. Ч.Чимэдрагчаа, Т. Алимаа, Н.Төмөрбаатар “Монгол анагаах ухааны идээ ундаан засал” УБ, “Мөнхийн үсэг” ХХК, 2012. 27.5 хх
4. Б.Дагвацэрэн, Ө.Батчимэг, Т.С. Варламова, Г.Наранцэцэг. “Өвчнөөс сэргийлэх уламжлалт анагаах ухааны ёс” УБ.2003.
5. Н.Оюунцэцэг, Д.Цэнд-Аюуш, Н.Төмөрбаатар, Т.Алимаа. “Монгол анагаах ухааны засал”. Улаанбаатар, 3 дахь хэвлэл, 2014. 20 хх.